

**Монгол Улсын Үндэсний номын сангийн Ёс зүйн дэд хорооны  
2025 оны жилийн эцсийн тайлан**

Ёс зүйн дэд хороо нь 2025 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 1 гишүүнийг нөхөн сонгох санал асуулгыг нийт ажилчдын дунд 10 хоногийн хугацаанд нээлттэй цахимаар явуулж сонгосон ба 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, дэд хорооны 1 удаагийн хурал хийж, 2025 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлуулж, баталсан төлөвлөгөөний дагуу ажилласан.

Ёс зүйн дэд хорооны гишүүд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, ёс зүйн зөрчил бүртгэл хяналтын дэд систем" сэдэвт сургалтад 09:00-10:40 цагийн хооронд цахимаар хамрагдсан. Мөн ЁЗДХ-ны гишүүдийг чадавхижуулах 2 удаагийн танхимын сургалтад бүх гишүүд хамрагдсан.



Цахим системд (ХНУМТ ЦАХИМ СИСТЕМ) ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг бүртгэж, төлөвлөгөө, тайлан мэдээг тухай бүр оруулсан.

Байгууллагын фэйсбүүк группт 7 удаа, Ёс зүйн дэд хороодын нэгдсэн группт 1 удаа мэдээлэл оруулж, 10 материалаар нийт ажилчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг суртчилан таниулж ажилласан.

Мөн МУҮНС-ийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх танхимын нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

Үйл ажиллагааны тайлбар болон зураглал:


➤ МУҮНС-ийн Ёс зүйн дэд хорооны 1 гишүүний нөхөн сонгууль /цахимаар/






- "7:4:10" сургалт "Төрийн албан хаагчийн ёс зүй" (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх) /цахимаар/,
- 7:4:10 сургалт. "Төрийн албан хаагчийн ёс зүй" (Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа) /цахимаар/,
- 7:4:10 сургалт. "Төрийн албан хаагчийн ёс зүй" (Дижитал ёс зүй) /цахимаар/,




- "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 15 заалтаар нийт 18 ширхэг инфографик бэлтгэж, "Дэлхийн ёс зүйн өдөр"-ийг тохиолдуулан 2025-10-15 өдөр байгууллагын дотоод группт болон 2025-11-10 өдөр Ёс зүйн дэд хороодын нэгдсэн группээр дамжуулан мэдээлэл хүргэсэн.



- Сургалтын зар болон сургалт зохион байгуулагдсан талаарх мэдээ мэдээлэл бэлтгэж, байгууллагын дотоод группт 4 удаа оруулсан.




- МУҮНС-ийн албан хаагчдын дунд зохион байгуулагдсан нэгдсэн сургалтууд:
  1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх ЁЗДХ-той хамтран "ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРМЫН ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ СУРГАЛТ"-ыг 2025.06.04-ны өдөр нийт албан хаагчдын дунд танхимаар зохион байгуулсан ба тус сургалтад 58 албан хаагч хамрагдсан.




Нэгдсэн сургалтын дараа сургагч багш Э.Батхүлэг дэд хорооны гишүүдийг чадавхижуулах, өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаарх сургалт зөвлөгөөнд Ёс зүйн дэд хорооны бүх гишүүд хамрагдаж, дадлага кейс дээр ажиллан харилцан ярилцсан.

2. “Шинээр батлагдсан журам, шийдвэрийн танилцуулга” болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” сургалтыг 2025.10.28-ны Мягмар гарагт 08:30-09.30 цагийн хооронд Салбар номын сангийн 11 давхрын хурлын танхимд ССАЖЗЯ, МУҮНС-гийн Ёс зүйн дэд хороо хамтран зохион байгуулсан ба сургалтад өглөө ээлжний 31 албан хаагч хамрагдсан.



Нэгдсэн сургалтын дараа ССАЖЗЯ-ны ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Э.Хулангаас МУҮНС-ийн ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхижуулах сургалт авсан ба сургалтад бүх гишүүд хамрагдсан.



2025 онд Ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол ирээгүй болно.

Тайлан бэлтгэсэн:

МУҮНС-ийн Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг: . . . . . /Д.Бадамсүрэн/

Тайланг хянасан:

МУҮНС-ийн Ёс зүйн дэд хорооны дарга: . . . . . /П.Энхээ/

Тайлангийн 8 дугаар хавсралт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээ

2025 оны жилийн эцсийн байдлаар

| № | Байгуул<br>агын нэр                         | Ес зүйн<br>зөрчлийн<br>тооч<br>агуулга | Гомдол, мэдээллийг хүлээн авсан үндэслэл (тохирох<br>нүдэнд "1" тоог тавих) |            |                               |                                      |                                          | Ес зүйн зөрчил гаргасан төрийн албан<br>хаагчийн ангилал |                                 |                                 | Зөрчлийг анх буюу<br>даватан үйлдсэн аль<br>нь болох |     | Хэрхэн шийдвэрлэсэн тухай |                                                              |                                       |                                                             |                               |
|---|---------------------------------------------|----------------------------------------|-----------------------------------------------------------------------------|------------|-------------------------------|--------------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------------|---------------------------------|---------------------------------|------------------------------------------------------|-----|---------------------------|--------------------------------------------------------------|---------------------------------------|-------------------------------------------------------------|-------------------------------|
|   |                                             |                                        | Гомдлоор                                                                    | Мэдээллээр | Хөвлөл мэдээллийн<br>хэрэгсэл | Олон нийтийн сүлжээнд<br>нийтлэгдсэн | Байгууллагын дотоод<br>хяналтаар илэрсэн | Төрийн захиргааны<br>албан хаагч                         |                                 | Төрийн үйлчилгээний албан хаагч | Төрийн тусгай албан хаагч                            | Анх | Давтан                    | Ес зүйн зөрчлөл ёс зүйн<br>зөрчлийг шалган тогтоосон<br>эсэх |                                       |                                                             |                               |
|   |                                             |                                        |                                                                             |            |                               |                                      |                                          | Удирдах<br>албан<br>тушаалтан                            | Гүйцэтгэх<br>албан<br>тушаалтан |                                 |                                                      |     |                           | Ес зүйн зөрчил<br>тогтоогдсон гэж үзсэн                      | Ер зүйн зөрчил гаргаагүй<br>гэж үзсэн | Эрх бүхий албан<br>тушаалтны шийдвэрээр<br>шалгаж тогтоосон | Учлал гүйхгүй үүрэг<br>болгох |
| 1 | Монгол<br>Улсын<br>Үндэсний<br>номын<br>сан | Ес зүйн<br>зөрчил<br>гараагүй.         | 0                                                                           | 0          | 0                             | 0                                    | 0                                        | 0                                                        | 0                               | 0                               | 0                                                    | 0   | 0                         | 0                                                            | 0                                     | 0                                                           |                               |

Есзүйн дэд хорооны дарга, Номын санч-Мэдээллийн ажилтан ..... (П.Энхээ)  
(албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

(2025.11.28)